



Тархаасан: 2021 оны 4 дүгээр сарын 15



1000 хүнд ногдох төрөлт 0.3 пунктээр буурлаа.

Улсын хэмжээнд 2021 оны эхний улиралд 17 619 эх амаржиж, 17 752 хүүхэд төрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эх 911 (4.9%)-ээр, төрсөн хүүхэд 911 (4.9%)-ээр тус тус буурчээ.

Зураг 1. Төрөлт, жил бүрийн эхний улирлын байдлаар




1000 хүнд ногдох төрөлт өмнөх оны мөн үеэс 0.3 пунктээр буурсан байна.

1000 хүнд ногдох төрөлт Улаанбаатар хот болон Баян-Өлгий, Говьсүмбэр, Өмнөговь, Говь-Алтай, Ховд, Сүхбаатар, Орхон аймагт улсын дунджаас 0.2-0.9 пунктээр дээгүүр, харин Дорноговь, Дорнод аймагт ижил түвшинд, бусад аймагт 0.1-2.0 пунктээр доогуур байна.

Зураг 2. Нас баралт, жил бүрийн эхний улирлын байдлаар

Нас баралт 3 769 болж, өмнөх оны мөн үеэс 187 (4.7%)-гоор буурчээ. 1000 хүнд ногдох төрөлт 5.3,



нас баралт 1.1, ердийн цэвэр өсөлт 4.2 байна.

1000 хүнд ногдох нас баралт өмнөх оноос 0.1 пунктээр буурчээ. 1000 хүнд ногдох нас баралт Дорноговь, Дундговь, Дорнод, Сүхбаатар, Говь-Алтай, Завхан, Булган, Хөвсгөл, Говьсүмбэр, Хэнтий аймагт улсын дунджаас 0.1-0.2 пунктээр дээгүүр, харин Улаанбаатар хот болон Архангай, Орхон, Өвөрхангай, Дархан-Уул аймагт ижил түвшинд, бусад аймагт 0.1-0.4 пунктээр доогуур байна.

1000 хүнд ногдох ердийн цэвэр өсөлт Улаанбаатар хот болон Баян-Өлгий, Өмнөговь, Говьсүмбэр, Ховд, Орхон, Говь-Алтай, Сүхбаатар аймагт улсын дунджаас 0.1-1.2 пунктээр дээгүүр, харин Увс аймагт ижил түвшинд, бусад аймагт 0.1-1.9 пунктээр доогуур байна.

Хүснэгт 1. 1000 хүнд ногдох төрөлт, нас баралт, ердийн цэвэр өсөлт, бүс, аймаг, нийслэлээр, 2021 оны эхний улирлын байдлаар

Аймаг, нийслэл	Төрөлт	Нас баралт	Ердийн цэвэр өсөлт
Улсын дүн	5.3	1.1	4.2
Баруун бүс	5.5	1.0	4.5
Баян-Өлгий	6.2	0.8	5.4
Говь-Алтай	5.6	1.2	4.4
Завхан	4.7	1.2	3.5
Увс	5.2	1.0	4.2
Ховд	5.6	1.0	4.6
Хангайн бүс	4.7	1.1	3.6
Архангай	4.5	1.1	3.4
Баянхонгор	4.8	1.0	3.8
Булган	3.8	1.2	2.6
Орхон	5.5	1.1	4.4
Өвөрхангай	4.6	1.1	3.5
Хөвсгөл	4.8	1.2	3.6
Төвийн бүс	4.6	1.1	3.5
Говьсүмбэр	6.1	1.2	4.9
Дархан-Уул	5.2	1.1	4.1
Дорноговь	5.3	1.3	4.0
Дундговь	4.9	1.3	3.6
Өмнөговь	6.0	0.7	5.3
Сэлэнгэ	3.5	1.0	2.5
Төв	3.3	1.0	2.3
Зүүн бүс	5.2	1.3	3.9
Дорнод	5.3	1.3	4.0
Сүхбаатар	5.6	1.3	4.3
Хэнтий	4.9	1.2	3.7
Улаанбаатар	5.6	1.1	4.5

Тайлбар: Эрүүл мэндийн яамны төрөлт, нас баралтын мэдээнд үндэслэн тооцов.

Ойлголт, тодорхойлолт: Хүн амын ердийн цэвэр өсөлтийг төрөлт, нас баралтын зөрүүгээр тодорхойлно.

Эх үүсвэр: Эрүүл мэндийн яамны төрөлт, нас баралтын мэдээлэл

Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархах хуваарь: 2021 оны 7 дугаар сарын 19

Хүн ам, нийгмийн статистикийн газрын
дарга А.Амарбал
Утас : (976-51)-264805

Хүн ам, нийгмийн статистикийн газар Хүн ам,
орон сууцны тооллогын товчооны статистикч
Т.Ариунсайхан
Утас : (976-51)-267547

